



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот.

Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11.

Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315.

E-mail: info@mrttd.gov.mn, http://www.mrttd.gov.mn

2022.09.06 № 03/4046
танай _____-ны № _____-т

**Г САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН САНГИЙН
ГАЗАРТ**

Зам, тээврийн хөгжлийн яамны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах дансанд байршиж байгаа үлдэгдлээс хавсралтад заасан "Жол" ХХК-д гэрээний дагуу олгох 39,290,025.50 (гучин есөн сая хоёр зуун ерэн мянга хорин таван төгрөг тавин мөнгө) төгрөгийн эрхийг зохих журмын дагуу нээж өгнө үү.

Хавсралт...⁹... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.БАТБОЛД



080002974

Боловсруулсан:

Хянасан:

Хувь: 2

Огноо: 2022.09.06

A handwritten signature in blue ink, appearing to be 'Дорсанбаа' (Dorsamba), written in a cursive style.

Зам, тээврийн хөгжлийн яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах данснаас барьцаа хөрөнгө олгох жагсаалт

2022.09.06 /төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	2022 оны эхний үлдэгдэл	2022 онд нэмэгдсэн орлого	2022 онд олгосон дүн	Одоо олгох дүн	Үлдэгдэл	Гэрээний заалт	Шийдвэр
	Эрх нээлгэх нийт дүн		39,290,025.50	0.00	0.00	39,290,025.50	0.00		
1	Согоогийн голын төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус сум/	"Жол" ХХК	39,290,025.50			39,290,025.50	0.00	Тусгай нөхцлийн 32.0. Чанарын баталгаат хугацаа 3 жил байна.	Авто зам, замын байгууламжийг байнгын ашиглалтад авах ажлын хэсгийн 2019.07.20-ны өдрийн 10/01/19 дугаартай акт, дүгнэлт, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Засаг даргын 2022.08.29-ний өдрийн 1/239 тоот албан бичиг

Хянасан:

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн дарга

Боловсруулсан:

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн шинжээч



Д.Гэрэлням

Ч.Ренчиндамба



Н.Баярсайхан



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
УЛААНХУС СУМЫН ЗАСАГ ДАРГА

83170 Билүү төв, Улаанхус сум, Баян-Өлгий аймаг,
Утас: (976) 7042-5201

2022.08.29 № 1/239

танай _____-ны № _____-г

“ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ”
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТЭСТ

Тус сумын “Жол” ХХК-ны хийж гүйцэтгэж
2019 онд ашиглалтад оруулсан. Улаанхус сумын
Согоог голын 18.7 км төмөр бетон гүүр 2.29 км
хайрган хучилттай авто замын баталгаат хугацаа
дууссан ба уг хугацаанд гүүрэнд ямар нэгэн эвдрэл
гэмтэл гараагүй болно.

ДАРГА  К. БАЯРДУЛЕТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАМ, БАРИЛГА ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
"ЖОЛ" ХХ КОМПАНИ

212100 Өлгий, Баян-Өлгий аймаг
Утас: 70422711 Факс: 70422711

2022.08.22 № 112

Танай _____-ны № _____

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТЭСТ

Хүсэлт тавих тухай

Тус Компанийн хийж гүйцэтгэн 2019 онд ашиглалтад оруулсан Согоогын голын 18,7 у/м төмөр бетон гүүр 2,29 км хайрган хучилттай авто замын баталгаат хугацаа дууссан тул барьцаа хөрөнгийн зохих журмын дагуу шийдвэрлэж өгнө үү.

Холбогдох материалыг хавсаргав.

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Б.КӨКСЕГЕН

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:
ЗЭМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ ГЭРЭЙН НАРИЙН
БИЧГИЙН ДААМ

С.БАТБОЛД

ГҮЙЦЭТГЭГЧ:
"ЖОЛ" ХХК-ИЙН
ЗАХИГАГЧ

Р.ЖАКСЕГЕН

СУМЫН ТӨВИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО-ЗАМ /БАЯН-ӨЛГИЙ,
УЛААНХУС СУМ/ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2021 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

№ 118

Улаанбаатар хот

Нэг талаас Зам, тээврийн хөгжлийн яам цаашид захиалагч гэх, нөгөө талаас "ЖОЛ" ХХК цаашид гүйцэтгэгч гэх дараах зүйлийг Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцож 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Монгол Улсын Иргэний хууль, Авто замын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга, зэм, замын байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах, замын зураг тасал боловсруулахтай холбогдсон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино
- 1.2. Захиалагч нь **Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Баян-Өлгий, Улаанхус сум/ ажлыг** (цаашид "ажил" гэх) 4 194 298 160 /дөрвөн тэрбум нэг зуун ерэн дөрвөн сая хоёр зуун ерэн найман мянга нэг зуун жар /төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно
- 1.3 Гэрээний нийт дүн: 4 194 298 160 төгрөг
- 1.4. Гүйцэтгэгч нь ажлыг 2021 оны 05 дугаар сарын 17-ний өдөр эхэлж, 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор захиалагчид хүлээлгэн өгнө
- 1.5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно. Цаашид гэрээний бичиг баримт гэх. Үүнд
 - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - Гэрээний ерөнхий нөхцөл;
 - Гэрээний тусгай нөхцөл;
 - Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь;
 - Гүйцэтгэлийн баталгаа;
 - Бусад шаардлагатай баримт бичиг
- 1.6. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд зөрчигдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
- 1.7 Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ
- 1.8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл болзолд нийцүүлэн гэрээнд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил гөлөгдөл арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

2021 118

- 1.9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний талбарийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 1.10. Ажлын чанарын баталгаат хугацаа 3 жил байх бөгөөд энэ хугацаанд авдрал, гэмтэл гарсан тохиолдолд гүйцэтгэгч тал өөрийн хөрөнгөөр 100% хохирлыг барагдуулна.

Хоёр. Бусад зүйл


2.1. Талууд энэхүү гэрээтэй холбогдон үүссэн маргааныг харилцан ойлголцож, эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

2.2 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт орох тохиолдолд хоёр тал албан бичгээр зөвшилцөнө.


Талууд:

ЗАХИАЛАГЧИЙН ТАЛААС


Зам, тээврийн хөгжлийн яамны
Авто замын бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч

 Д.Загдраднаа

Зам, тээврийн хөгжлийн яамны
Бодлого, төлөвлөлтийн газрын
Санхүү, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга


 Ч.Ренчиндамба

Зам, тээврийн хөгжлийн яамны
Төрийн захиргааны удирдлагын газрын
Хуулийн хэлтсийн шинжээч

 Б.Билгүүн


ХЯНАСАН

Зам, тээврийн хөгжлийн яамны
Төрийн захиргааны удирдлагын газрын
Хуулийн хэлтсийн дарга


 Н.Бат-Эрдэнэ

ГҮЙЦЭТГЭГЧИЙН ТАЛААС

"ЖОЛ" ХХК-ийн ерөнхий
инженер

 Ж.Досымбек

"ЖОЛ" ХХК-ийн ерөнхий
нягтлан

 Д.Бахытгул

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Чингисийн өргөн чөлөө-11, Засгийн
газрын XIII байр
Утас: 976-62263179
Факс: (976-11) 312315

Баян-Өлгий аймаг, Өлгий сум
3 дугаар баг
Утас: 99999553, 99410013
Харилцагч банк: Капитрон банк
Дансны дугаар: 3005002420

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ БАЙНГЫН АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ ХЭСГИЙН ДҮГНЭЛТ**

2019 оны 7 сарын 10 ны өдөр Дугаар 10/01/19

Улаанбаатар хот

НЭГ. Ерөнхий мэдээлэл

1.1 Авто зам, замын байгууламж, объектын нэр: **Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Согоогийн 18.7 урт метр төмөрбетон гүүр, 2.29 км хайрган хучилттай авто зам**

Хүчин чадал, байршил, хэмжээ, үндсэн бүтээц: **Согоогийн голын 18.7 урт метр төмөрбетон гүүр, 2.29 км хайрган хучилттай авто замын барилгын ажил**

Зургийн шифр: **ЗТ 03/2013** Магадлалын дугаар:

Хаяг: **Баян-Өлгий аймаг /нийслэл/ Улаанхус сум /дүүрэг/, 7 дугаар баг**

1.2 Ерөнхий гүйцэтгэгч байгууллагын нэр, хаяг: **"Жол" ХХК, Өлгий сум 3 дугаар баг**

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: **000155827/ 2003864**

1.3 Туслан гүйцэтгэгч байгууллагын нэр, хаяг: **байхгүй**

1.4 Зураг төслийн байгууллагын нэр, хаяг: **"ХЗТ авто зам" ХХК, Баянзүрх дүүрэг 18-р хороо, 13-р хөрөөлөл, 37-р байр-27 тоот**

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: **9011015129/ 2599473**


1.5 Захиалагч байгууллагын нэр, хаяг: **Зам, тээврийн хөгжлийн яам, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-11, Засгийн газрын XIII байр**

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: **9070005146/5634768**

1.6 Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ эрхлэгч байгууллагын нэр, хаяг: **"Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ, Баянгол дүүрэг, 20-р хороо "ЗТХТ" ТӨҮГ-ын байр**

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: **9013001050/ 5645913**

1.7 Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан 194 дугаар тушаалаар томилогдсон 15 хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг нь уг авто зам, замын байгууламжийг ашиглалтад



бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг нь уг авто зам, замын байгууламжийг ашиглалтад авахад бэлэн болсон тухай "Жол" ХХК-ийн 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 46 тоот албан бичгийн дагуу 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр шинээр барьсан авто зам, замын багууламжийн барилгын ажлын чанар, холбогдох баримт бичиг, материалуудтай танилцаж газар дээр нь ажиллаж, үзлэг шалгалт хийв.

1.8 Энэхүү Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Согоогийн голын 18.7 урт метр төмөрбетон гүүр, 2.29 км хайрган хучилттай авто замыг ЗТ 09/2 шифртэй зураг төслөөр 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдөр барьж дуусгасан байна.

ХОЁР. Ажлын хэсгийн шийдвэр

Энэхүү Согоогийн голын 18.7 урт метр төмөрбетон гүүр, 2.29 км хайрган хучилттай авто замын зураг төсөл, холбогдох баримт бичиг, ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр ашиглалтад авах ажлын хэсгээс **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

2.1 Энэхүү авто зам, замын байгууламж нь зураг төслийн дагуу бүрэн хийгдэж дууссан Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Согоогийн голын 18.7 урт метр төмөрбетон гүүр, 2.29 км хайрган авто замыг үйлчилгээний зориулалтаар ашиглахад хангасан гэж үзээд захиалагч байгууллага Зам, тээврийн хөгжлийн яам, хариуцагч (ашиглагч) байгууллага болох Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Заса даргын Тамгын газрын мэдэлд 20... оны ... сарын ... -ны өдрөөс ашиглалтад авахыг зөвшөөрөв.

2.2 Уг Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Согоогийн голын 18.7 урт метр төмөр бетон гүүр, 2.29 км хайрган хучилттай авто замыг үндсэн хөрөнгийг 1 572 010 375 төгрөгөөр үнэлэв.


2.3 Авто зам, замын байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан Ажлын хэсгээс даалгах нь:

Гүйцэтгэгч байгууллагад:

1. "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлж, ашиглалтад авах журам"-ын 4 дүгээр хавсралтын В хэсэгт заасан баримт бичгийн бүрдлийг хангаж, техник технологийн хяналтын зөвлөх байгууллагаар хянуулан архивд эх хувийг, үлдсэн хувийг тухайн авто зам, замын байгууламжийн эзэмшигч, зам хариуцагч байгууллагад ... хоногийн дотор хүлээлгэн өгч, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг хийх;
2. Авто замын тухай хуульд заасны дагуу гүйцэтгэгч, техник технологийн хяналтын зөвлөх байгууллага авто зам, замын байгууламжийг ашиглалтад хүлээн авснаас хойш чанарын баталгааны 3 жилийн хугацаанд тухайн замд илэрсэн зөрчил барилгын ажлын чанараас шалтгаалсан технологийн эвдрэл гэмтлийг бүрэн хариуцах.

Зам хариуцагч (ашиглагч) байгууллагад:

1. Авто замын тухай хуулийн 27.3-т заасны дагуу авто зам, замын байгууламжийн паспорт, картыг хянаж, хүлээн авч, бүртгэл мэдэээлийн санд



баяжилт хийж, холбогдох мэдээллийг жил бүрийн тогтоосон хугацаанд авто зам эзэмшигчид хүргүүлж байх.

2. Авто замын тухай хуулийн 23.3-т заасны дагуу чанарын баталгаат дууссанаас хойш авто зам, замын байгууламжийн ашиглалтын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, арчлалт, засварын ажлыг тогтоосон хугацаанд тогтмол хийж байх.

3. Ажлын хэсгийн дүгнэлт хуудас, хуралдааны тэмдэглэл 7 хуудас, өгсөн үүрэг даалгаврын биелэлт хуудас материал, авто зам, замын байгууламжийн баримт бичгийн жагсаалтыг хавсаргав.

ГУРАВ. Дүгнэлтийн баталгаажуулалт

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛААНХУС СУМЫН СОГООГИЙН ГОЛЫН 18.7 УРТ МЕТР ТӨМӨРБЕТОН ГҮҮР, 2.29 КМ ХАЙРГАН ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН АЖЛЫГ БАЙНГЫН АШИГЛАЛТАД АВАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Ажлын хэсгийн дарга:


Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Үам, тээврийн хяналтын хэлтсийн дарга



Я.Мөнхжаргал

Нарийн бичгийн дарга:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Зам, тээврийн хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, улсын байцаагч



Ц.Батжаргал

Гишүүд:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Зам, тээврийн хяналтын хэлтсийн мэргэжилтэн, улсын байцаагч



Х.Энэрэлсайхан

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн



Б.Гийвийшинэн

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн




Л.Баянзул


11/11/11

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛААНХУС СУМЫН СОГООГИЙН ГОЛЫН
18.7 УРТ МЕТР ТӨМӨРБЕТОН ГҮҮР, 2.29 КМ ХАЙРГАН ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ,
ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН ДҮГНЭЛТ


“ХЗТ-Авто зам” ХХК-ийн
ерөнхий инженер

 Х.Ариунболд

“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын
Барилга угсралтын хяналтын хэлтсийн
хяналтын инженер

 Х.Алтанхуяг


Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө
оруулалт Хөгжлийн бодлого, төлөвлөлийн
хэлтсийн дарга

 З.Болат


Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын
газрын Авто замын хяналтын улсын байцаагч

 М.Байдол


Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын
Засаг дарга

 О.Нурлан

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын
Байгаль орчны хяналтын улсын байцаагч

 Б.Есерхан


Баян-Өлгий аймгийн Цагдаагийн газрын,
замын Цагдаагийн тасгийн байцаагч,
Цагдаагийн ахмад

 А.Мырзабек


Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын
Гал түймрийн хяналтын улсын байцаагч,
Ахлах дэслэгч


 Х.Ербулан

Баян-Өлгий аймгийн “Жол” ХХК-ийн
ерөнхий захирал

 Б.Көксеген

Зам, тээврийн хөгжлийн яамны
архивын эрхлэгч

 Д.Дэлгэрмаа





МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн Хяналтын Газар
Өлгий сум 3-р баг Утас/Факс: (976) 7042-2338
www.inspection.gov.mn

2022.08.22. № 04-04-036/129.

Улаанхус сумын Согоогийн голын 18.7 у/м
төмөр бетон гүүр, 2.29 км хайрган хучилттай
авто замын ашиглалтын тухай

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
ЯАМНЫ АВТО ЗАМЫН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ
ГАЗАРТ

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан 2022 оны 04/30 тоот удирдамж, Зам, барилга үйлдвэрлэлийн “Жол” ХХК-ийн 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 110 тоот албан бичгийн дагуу Өлгий-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн орон нутгийн чанартай авто замын Улаанхус сумын Согоогийн голын 18.7 у/м төмөр бетон гүүр, 2.29 км хайрган хучилттай авто замын ашиглалтын байдлыг “Жол” ХХК-ийн ерөнхий захирал Б.Көксеген, ерөнхий инженер М.Муратбек нарыг байлцуулан 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдөр шалгаж үзлээ.

Баян-Өлгий аймгийн Өлгий-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн орон нутгийн чанартай авто замын Улаанхус сумын Согоогийн голын 18.7 у/м төмөр бетон гүүр, 2.29 км хайрган хучилттай авто замын барилгын ажлын:

Захиалагч: Зам, тээврийн хөгжлийн яам

Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ эрхлэгч байгууллага:
“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ

Гүйцэтгэгч: Зам, барилга үйлдвэрлэлийн “Жол” ХХК

Зураг төсөл: Улаанхус сумын Согоогийн голын 18.7 у/м төмөр бетон гүүр, 2.29 км хайрган хучилттай авто замын ажлын зураг төслийг Авто зам, гүүрийн зураг төслийн “ХЗТ-Авто зам” ХХК ЗТ 09/2013 шифртэй боловсруулж, улсын экспертизээр 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Барилгын хөгжлийн төвд хянуулсан байна.

Согоогийн голын төмөр бетон гүүр нь Өлгий-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн орон нутгийн чанартай авто замд байрладаг, Өлгий сумын төвөөс 45 км-ын зайтай, 18.7 м урттай, 10.5 м өргөнтэй, 8 м өргөн зорчих хэсэгтэй, (0.75x2) м өргөн явган хүний замтай 1.2 м өндөр хайстай, 0.35 м өндөр хашлагатай, 1 алгасалтай, баганат, төмөр бетон хөл тулгууртай гүүр байна.

13
2

THE
STATE OF
NEW YORK
IN SENATE
January 15, 1903.

REPORT
OF THE
COMMISSIONERS OF THE
LAND OFFICE
IN RESPONSE TO A
RESOLUTION PASSED
BY THE SENATE
MAY 17, 1902.

ALBANY:
J. B. WARD, STATE PRINTER,
1903.

Гүүрийн хоёр талын замын урт: баруун эрэг L₆ = 2015.37 м, зүүн эрэг L₃ = 274.63 м, хучилтын төрөл нь хайрган хучилт, замын зорчих хэсгийн хөдөлгөөний зурвасын тоо 2, хөвөөний өргөн явганаар зорчих хэсгийн хамт 2.0 м байна.

Гүүрийн байр зүйн судалгааг "Геотес" ХХК, инженер геологи болон инженер гидрологийн судалгааг "Ган хошуу" ХХК хийсэн.

Гүүрийн ашиглалтын байдалд 5.17 дугаарын "Авто зам, замын байгууламжийн ашиглалтын байдлыг шалгах хяналтын хуудас"-аар шалгахад 25 хувь буюу "бага" эрсдэлтэй үнэлэгдсэн.

Авто зам, замын байгууламжийг ашиглалтад авах ажлын хэсэг Улаанхус сумын Согоогийн голын 18.7 м урт, тэнхлэгээрээ 11 тн даацын хязгаартай төмөр бетон гүүр, 2.29 км хайрган хучилттай авто замыг 2019 оны 06 дугаар 12-ны өдөр улсын ашиглалтанд авч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээж, ажлын хэсгийн 2019 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 10/01/19 тоот акт, дүгнэлтээр албажуулсан байна.

Ажлын хэсгийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар болон Авто замын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.1-д "авто замын ашиглалтын байнгын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангах", 23.3.2-д "авто замд тогтоосон журмын дагуу үзлэг хийж, арчлалт, засварын ажлыг тогтмол гүйцэтгэх, авто замаар зорчигчдоос зам, замын байгууламжийн эвдрэл гэмтлийн талаар мэдээлэл авч, шуурхай арга хэмжээ авах" гэж заасныг "Жол" ХХК биелүүлсэн байна.


Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн

10.9.13-д заасныг үндэслэн ДҮГНЭЛТ БОЛГОХ нь:

1. Өлгий-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн орон нутгийн чанартай авто замын Улаанхус сумын Согоогийн голын 18.7 м урт төмөр бетон гүүр, 2.29 км хайрган хучилттай авто замын ашиглалт нь чанарын баталгаат гурван жилийн хугацаанд норм, дүрэм, стандартын шаардлагыг хангасан байна.

2. Цаашид гүүр, замын ашиглалт, хамгаалалт, засвар арчлалтын ажлыг орон нутгийн авто замын засвар арчлалтын байгууллага хариуцан БНБД 13-03-00 "Авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтын арга технологи"-ийн дагуу гүйцэтгэж байх шаардлагатай байна.

3. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн



14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргах эрхтэй.

Фото зургуудыг хавсаргав.

Хувийг: Зам, барилга үйлдвэрлэлийн "Жол" ХХК-д

АВТО ЗАМЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ




И.БАЙДОЛ

ДҮГНЭЛТТЭЙ ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

ЖОЛ ХХК-ИЙН ЕРӨНХИЙ
ИНЖЕНЕР

Муратбек

М.МУРАТБЕК





Гүүрийн будагийг сэргээж будсан нь



Handwritten marks and symbols, including a small cluster of lines and a horizontal line below.


Handwritten marks and symbols, including several horizontal lines and scattered dots.

Гүүрийн хайс болон дугуй цохигчийг сэргээн будаж байгаа нь





БАТЛАВ:



**СОГООГИЙН ГОЛЫН ТӨМӨР БЕТОН ГҮҮР /БАЯН-ӨЛГИЙ,
УЛААНХУС СУМ/ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2018 оны 06 дугаар сарын 13-ны өдөр

№ 26

Улаанбаатар хот


Нэг талаас Зам, тээврийн хөгжлийн яам /цаашид захиалагч гэх/, нөгөө талаас "ЖОЛ" ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/ дараах зүйлийг Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд харилцан тохиролцож 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Монгол Улсын Иргэний хууль, Авто замын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга, зам, замын байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах, замын зураг төсөл боловсруулахтай холбогдсон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2. Захиалагч нь Согоогийн голын төмөр бетон гүүр /Баян-Өлгий, Улаанхус сум/ ажлыг (цаашид "ажил" гэх) 1 572 010 375 /нэг тэрбум таван зуун далан хоёр сая арван мянга гурван зуун далан тав/ төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 1.3. Гэрээний нийт дүн: 1 572 010 375 төгрөг.
- 1.4. Гүйцэтгэгч нь ажлыг 2018 оны 06 дугаар сарын 13-ний өдөр эхэлж, 2018 оны 11 дугаар сарын 10-ны өдрийн дотор захиалагчид хүлээлгэн өгнө.
- 1.5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно. /цаашид гэрээний бичиг баримт гэх/. Үүнд:

- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- Гэрээний ерөнхий нөхцөл;
- Гэрээний тусгай нөхцөл;
- Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь;
- Гүйцэтгэлийн баталгаа;
- Бусад шаардлагатай баримт бичиг.

- 1.6. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд зөрчигдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.



(Handwritten signature)

- 1.7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
- 1.8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн гэрээнд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
- 1.9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 1.10. Ажлын чанарын баталгаа зүгшрүүлэх, тохируулах хугацаа 1 жил, хэвийн ашиглалтын хугацаа 3 жил байх бөгөөд энэ хугацаанд эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд гүйцэтгэгч тал өөрийн хөрөнгөөр 100% хохирлыг барагдуулна.

Хоёр. Бусад зүйл

2.1. Талууд энэхүү гэрээтэй холбогдон үүссэн маргааныг харилцан ойлголцож, эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

2.2. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт орох тохиолдолд хоёр тал албан бичгээр зөвшилцөнө.

Талууд:

ЗАХИАЛАГЧИЙН ТАЛААС :
ТАЛААС:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ

Зам, тээврийн хөгжлийн яамны
Авто замын бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын Замын ашиглалт,
засварын хэлтсийн дарга

..... /Х.Орвил-Эрдэнэ

"ЖОЛ" ХХК-ийн
ерөнхий инженер

..... /М.Муратбек/

Зам, тээврийн хөгжлийн яамны
Бодлого, төлөвлөлтийн газрын
Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн
хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч


..... /Ч.Ренчиндамба

"ЖОЛ" ХХК-ийн
ерөнхий нягтлан бодогч

..... /Д.Бахытгүл/


Зам, тээврийн хөгжлийн яамны
Төрийн захиргааны удирдлагын газрын
Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

..... /Д.Оюунсүрэн



Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Чингисийн өргөн чөлөө-11, Засгийн
газрын XIII байр
Утас: 976-62263179
Факс: (976-11) 312315

Баян-Өлгий аймаг, Өлгий сум
3 дугаар баг
Утас: 99999553, 99102176
Харилцагч банк: Капитрон-банк
Дансны дугаар: 3005002420



Handwritten signature or mark.